



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/56

Дархан

Хориглосон бүсэд байгаа мал, туслах  
аж ахуйг нүүлгэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 13.1.5, 14 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 99 дүгээр тогтоол, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчийн 2016 оны 10 дугаар тогтоол, Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1, 2, 3, 5, 6, 7, 8, 15 дугаар багийн нутаг дэвсгэрт байгаа туслах аж ахуйг (гахай), 5, 6, 7, 8, 15 дугаар багийн мал бүхий өрхүүдийг холбогдох хууль, журмын дагуу "Эрчимжсэн мал аж ахуй", "Туслах аж ахуй"-н суурьшлын бүсэд 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нүүлгэн шилжүүлсүгэй.

2. Мал, туслах аж ахуйг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Шинэ суурьшлын бүсэд шилжин суурьших боломжгүй өрхүүдийг мал, туслах аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс заагдсан хугацаанд бүрэн гаргахыг ажлын хэсэг (П.Ихбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.ТУЛГАА

D.ajil.Zahiramj-2022

4522060349

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 02 дугаар сарын 30 ны өдрийн  
ээлжит 8 дугаар хуралдааны 11 дугаар  
тогтоолын 19 хавсралт



ХОРИГЛОХ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙН  
СОЛБИЛЦЛЫН ЖАГСААЛТ

№	Хилийн цэсийн тоотын нэр	Өргөрөг /WGS84/	Уртраг /WGS84/
1	Ногоон модны гүүр /1-р шон/	49°30'46.3000"	105°53'52.4000"
2	Засмал замын 230-р км-н шон	49°31'45.5900"	105°58'04.9000"
3	Шар гозгор	49°31'14.5000"	105°59'12.3900"
4	Их булангийн уул	49°31'01.1900"	106°01'12.8900"
5	Баянхонгор	49°30'04.3000"	106°01'08.3900"
6	Талын толгой/3-р шон/	49°28'15.8000"	106°01'17.1000"
7	4-р шон	49°27'27.6900"	106°00'50.0000"
8	5-р шон	49°26'35.4000"	106°00'05.9000"
9	Цагаан гозгор	49°25'53.9900"	105°59'26.5900"
10	Элсэн эрэг /6-р шон/	49°25'04.2000"	105°56'39.4000"
11	Засмал замаар Улаанбаатар- Эрдэнэтийн засмал замын уулзвар	49°22'43.6900"	105°54'59.3900"
12	Ухаа хушууны гүүр	49°23'22.6900"	105°53'49.8900"



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн  
ээлжит 8 дүгээр хуралдааны 14 дугаар  
тогтоолын 2-р хавсралт

ХОРИГЛОХ БҮСИЙН ЗУРАГ

